



**A FUTURE FOR THE TAKHI  
AND THE DZUNGARIAN GOBI**

**EINE ZUKUNFT FÜR DAS WILDPFERD  
UND DIE DZUNGARISCHE GOBI**

**International Takhi Group**  
c/o Wildnispark Zürich  
alte Sihltalstrasse 38  
CH - 8135 Sihlwald  
(Switzerland)

Phone: +41 44 722 55 22

[www.savethewildhorse.org](http://www.savethewildhorse.org)  
[info@savethewildhorse.org](mailto:info@savethewildhorse.org)

Raiffeisen Bank, 8001 Zürich  
CHF: CH51 8148 7000 0053 1847 2  
EUR: CH79 8148 7000 0053 1845 3  
USD: CH90 8148 7000 0053 1844 9  
SWIFT-BIC: RAIFFCH22

Contact:  
Thomas Pfisterer, President  
Chris Walzer, Research  
Christian Stauffer, Executive Secretary



## WHAT ARE DONATIONS NEEDED FOR?

The International Takhi Group (ITG) programme needs a sustainable financial base for implementation of management decisions, interdisciplinary monitoring and research, as well as for training, capacity building and empowerment of local scientists and residents.

## BEYOND WILD HORSES

While the ITG programme started out initially as a single-species re-introduction project, the magnitude of the conservation activities has greatly expanded in recent years. Integrated research projects dealing with the Asiatic wild ass, grey wolf, wild Bactrian camel, various rodent species and vegetation have been implemented. Whereas the initial re-introduction efforts were driven mostly by health concerns for the horses, the disciplinary scope has also significantly broadened: Zoologists, geographers and botanists have collaborated on habitat mapping and assessment, and community development experts are working to establish a socio-economic framework for future project development.

## WHERE DOES THE MONEY GO?

Your donations will be invested on location in Mongolia exclusively; the executive board of the ITG works on voluntary basis.

## OPTIONS TO HELP

### USD 15'000

Translocate 4 Takhis from China

### USD 5'000

Collar 1 Takhi with GPS radio transmitter

### USD 3'000

Fuel cost for one month

## ТАНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ЮҮНД ХЭРЭГТЭЙ ВЭ?

Монголд тахь нутагшуулах менежментийг хэрэгжүүлэх, мониторинг судалгаа, сургалт зохион байгуулах, залуу судлаачид, нутгийн иргэдийг чадавхжуулах үйл ажиллагаа явулахад Олон улсын тахь групп /ОУТГ/-д санхүүгийн тогтвортой эх үүсвэр хэрэгтэй байна.

## ТАХЬ НУТАГШУУЛАХ ҮНДСЭН АЖЛААС БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА.

ОУТГ нь нэн ховор туурайтан амьтны нэг зүйлийг сэргээн нутагшуулах төслийг эхлэн хэрэгжүүлж байсан бөгөөд сүүлийн жилүүдэд байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн хамт хулан адuu, саарал чоно, хавтгай тэмээ, жижиг мэрэгчдийг судлах талаар амжилттай ажиллаж байна.

Тахь сэргээн нутагшуулах төслийн эхэн үед зөвхөн тахийн нутагшилт, үржил, өвчин эмгэгийн асуудалд түлхүү анхааран ажиллаж байсан бол одоо амьтан судлаач, газар зүйч, ургамал судлаачдын өргөн бүрэлдэхүүнтэй баг хамтран экосистемийн цогц асуудалд анхаарч, тэнд амьдарч буй бусад ховор амьтдын амьдрах орчны зураглал хийж оролцож байна. Мөн уг төслийн хүрээнд орон нутгийн амжиргааг дэмжих нийгэм, эдийн засгийн төслүүдийг орчны бүс нутагт эхлүүлээд байна.

## САНХҮҮЖИЛТ ХААНА ЗАРЦУУЛАГДАХ ВЭ?

Таны өгсөн санхүүгийн хандив төслийг хэрэгжүүлж буй Монголын орон нутагт зарцуулагдана. ОУТГ-ын гүйцэтгэх зөвлөл, удирдлага бүгд сайн дураар ажилладаг.

## MÖGLICHKEITEN ZU HELFEN

### USD 15'000

Umsiedlung von 4 Takhis aus China

### USD 5'000

1 Takhi mit GPS Telemetrie Halsband besendern

### USD 3'000

Treibstoff für einen Monat

## TAKHI – THE LAST WILD HORSE

The Przewalski's horse (*Equus ferus przewalskii*) is the last true wild horse. Called "Takhi" in Mongolian, it became extinct in the wild during the 1960s. The reasons are seen in the combined effects of pasture competition with livestock and over-hunting. The last confirmed sighting of a Takhi in the wild occurred in the Dzungarian Gobi of SW Mongolia in 1968.

However, the Takhi survived in captivity. With the establishment of the Przewalski's horse stud-book at Prague Zoo and the initiation of a European Endangered Species Programme, the captive population had grown to over 1,000 individuals by the mid-1980s based on a mere 13 founder animals.

The Przewalski's horse's colour ranges from yellowish to reddish-brown with white nostrils. It features a compact body with a strong neck and heavy limbs. The shoulder height ranges from 125 to 147 cm, and it weighs between 240 and 300 kg.

The takhi's mane stands upright. From the mane to the tail blends a dark dorsal stripe. Unlike the domestic horse, the takhi's onset of the tail is prolonged downwards. The short hair in summer is replaced by a longer one with very thick sub-wool in winter.

## ТАХЬ БОЛ СҮҮЛЧИЙН ЦОРЫН ГАНЦ ЗЭРЛЭГ АДУУ

Пержевальскийн адуу буюу ТАХЬ нь дэлхийн сүүлчийн зэрлэг адуу бөгөөд өнгөрсөн зууны 60-аад оны үед зэрлэг өвөг нь байгальдаа бүрэн устсан юм. Устах болсон үндсэн шалтгаан нь хүн, малын нөлөөгөөр бэлчээр нутаг нь хомсадсон, хэт агналтын зохисгүй үр дагавар байсан гэж үздэг. Хамгийн сүүлд 1968 онд Монголын баруун өмнөд хэсэг Зүүнгарын говьд ганц тахь узэгдсэн мэдээ байдаг.

Гэсэн хэдий ч тахь нь амьтны хүрээлэнд гаршуулсан байдлаар үлдэж, амьдарч байсан бөгөөд Прага хотын амьтны хүрээлэнгийн хөтөлж буй тахийн удмын бичгийг үндэслэж Европын ховор зүйлүүдийг хамгаалах хөтөлбөрийн санаачлагаар 13 бодгалиас гаралтай тахь 1980 -аад оны дунд үед дэлхий дээр 1000 гаруй болтлоо ёсчээ.

Тахь шаргал хонгороос хул хонгор, хамар хошуу, хэвлийн хэсэг нь цайвар зүстэй, хүчирхэг богино бүдүүн хүзүү, баихим 4 хөлтэй. Мөрний өндөр нь 125-147 см, ойролцоогоор 240-300 кг хүнд жинтэй. Дэл нь үргэлж босоо байдаг, дэлний төгсгөлөөс сүүлний уг хүртэл нурууг дагасан гол нь хар зураастай. Сүүлний уг нь нэлээд уртассан бүдүүн байдгаараа гэрийн адуунаас ялгаатай. Зүн тачир үстэй, өвөл нь өтгөн хөөвөртэй.



## RE-INTRODUCTION

In 1992 the first group of captive-born takhi were selected from the breeding Center Askania Nova in the Ukraine and then airlifted to Takhin Tal at the edge of the Great Gobi "B" SPA. The logistics of these first transports were very difficult and the horses' journey was long and exhausting. Five years later, in 1997, a harem group was released into the wild from the adaptation enclosures, and in 1999 the first foals were successfully raised in the wild. Until 2004 a total of 89 horses from various European zoos were brought to the Dzungarian Gobi. Since then, further takhis arrived from China, Europe and another project in Mongolia.

Initially largely confined to the north-eastern corner of the protected area, range use of the re-introduced horse population increased gradually. Przewalski's horses are very conservative in their range use and tend to stay in the vicinity of the release facilities. Therefore, a harem group was successfully translocated to the Takhin Us water point about 120 km west of the original release site to speed up the expansion of the distribution range within the area. By 2009 the Takhin Tal population was entirely free-ranging and had grown to 137 animals. The winter 2009/2010 caused severe losses. In 2012 the population counted 75 animals.

Przewalski's horse groups are being checked by park rangers once or twice a week. The rangers are able to recognize individual animals based on their appearance. An additional 15 Przewalski's horses were tracked by satellite telemetry between 2001 and 2008.

## FLAGSHIP TAKHI

At the beginning of the project, the ITG focussed on the re-introduction of the Prze-walski's horse. However, long-term success depends first and foremost on the protection of the horses' entire habitat. Over the years, the Takhi has become a flagship species for the successful long-term preservation of the Dzungarian Gobi.

The success of the re-introduction project is clearly demonstrated by the changes in the IUCN, International Union for Conservation of Nature Red List status of the Przewalski's horse: From "extinct in the wild" in 1996 it was changed to "critically endangered" in 2008 and to the less critical status of "endangered" in 2011.

## СЭРГЭЭН НУТАГШУУЛАЛТ

1992 онд Україны Аскани-Новагийн тахь үржүүлгийн газарт төрсөн тахиас Монгол улсын Говийн их дархан газрын Б хэсэг Тахийн талд онгоцоор тээвэрлэн авчирч нутагшуулж эхэлсэн. Хамгийн анхны тээвэрлэлтийн зам урт байсан тул хэцүү, бэрхшээлтэй зүйлс цөөнгүй тохиолдох, тахиуд их ядарч байсан. Таван жилийн дараа анхны сурэг тахийг дасгах хашаанаас говийн задгай бэлчээрт суллан гаргасан бөгөөд 1999 онд анхны зэрлэг унаганууд байгальд амжилттай бойжих эхэлсэн. 2004 оныг хүртэл 89 тахийг янз бүрийн Европын амьтны хүрээлэнгүүдээс Зүүнгарын говьд аваачсан, түүнчлэн сүүлийн жилүүдэд Хятад, Европ болон Хустайгаас тахь тээвэрлэн авчрах ажлыг хийж үргэлжлүүлж байна.

Эхэн үедээ хамгаалалттай нутгийн зүүн хойд хэсгийн багахан нутагт тахийг нутагшуулахад популяцийн тоо толгой аажмаар өсөх хандлагатай байв. Тахь нь өөрийн байршиж дассан газраа тогтвортой байдаг зан төрхтэй амьтан тул тэднийг нутгийн баруун хэсэгт 120 км зaitай "Тахийн ус" гэдэг газар сэлгэн нутагшуулж, эзэмшил нутгийг нь тэлж өгсөн. 2009 оны байдлаар зэрлэг тахийн сурэг өсөж, 137 толгойд хүрээд байсан боловч байгалийн гамшигийн улмаас 2009-2010 оны өвөл нэлээд хородж багагүй хохирол амссан. Зүүнгарын говьд 2012 оны сүүлээр 75 тахь нутагшиж байна.

Дархан газрын байгаль хамгаалагчид тахийн сүргүүдийг долоо хоногт 1-2 удаа ажиглан хяналт тавьж ажиллаж байна. Тэдгээр хамгаалагч нар тахиудыг алсаас нэг бүрчлэн ялган таньж чаддаг. 2001-2008 онд 15 тахийг сансрын дохиоллын тусламжтай зайнаас танадан судалж, тэдний эзэмшил нутгийг тогтоосон юм.

## ТАХЬ АДУУ ЗҮҮНГАРЫН ГОВИЙН "БАХАРХАЛ" ЗҮЙЛ

Төслийг хэрэгжүүлэх эхний жилүүдэд Олон улсын тахь групп зөвхөн тахийг сэргээн нутагшуулах ажилд голлон анхаарч ажиллаж байсан бөгөөд цаашид амжилттай эхлүүлсэн энэхүү төслийн хүрээнд тахийн амьдрах орчинг хамгаалах чиглэлд анхаарлаа хандуулах шаардлага бий болсон.

Өнгөрсөн хугацаанд Зүүнгарын говийг удаан хугацаанд хамгаалах тогтвортой үйл ажиллагааны "бахархал" нь тахь болж чадсан юм.

Тахийг сэргээн нутагшуулах төслийн ажлуудын амжилтын үр дүнд энэ амьтны IUCN -ийн улаан дансны ховор зүйлийн статусыг өөрчилж чадсан юм. Жишээ нь: Тахийг 1996 онд байгальд "устсан" гэсэн ангилалтай байсныг 2008 онд "нэн ховордсон", 2011 онд "ховордсон" хэмээн шилжүүлэн өөрчилжээ.

## THE GOBI

The Mongolian Gobi in Central Asia constitutes a vast, largely intact and continuous stretch of non-equilibrium dry land which is home to several endangered or critically endangered large migratory ungulates and a millennium-old semi-nomadic livestock herding culture.

The 9,000 km<sup>2</sup> Great Gobi "B" SPA was chosen as the re-introduction site. Established in 1975, it encompasses some 9,000 km<sup>2</sup> of desert steppes and semi-deserts. Plains in the east and rolling hills to the west dominate the landscape, with the mighty Altai Mountains flanking the park in the north. The Takhin Shar Naruu Mountain in the south forms the international border with China. Elevations range from 1,000 to 2,840 m.a.s.l. The climate is continental, with long, cold winters and short, hot summers. Average annual temperature is a frigid 1° C and average annual rainfall a mere 96 mm. Snow cover lasts an average of 97 days. The defining factor for this landscape is that rain and snowfall are highly variable in space and time. Open water (rivers and springs) is unevenly distributed, with almost no water in the central and western part of the SPA.

Mongolia, often called the "land without fences", provides the last remaining refuge for a number of migratory species that require large areas of habitat. The livestock herders maintain a fragile grip on survival after enduring the political and economic upheaval wrought by the collapse of the socialist command economy. With Mongolia's transition to a privatised market economy, more people and exploitative economic activities – notably mining and road construction – could further impact environmental security and the habitat needs of the wildlife in the Gobi region.



## ГОВЬ НУТАГ

Төв Азийн онгон зэлүүд, өргөн уудам, харьцангуй хуурай нутагт Монгол орны нүүдэлч малчдын олон мянган жил нутаглаж ирсэн өлгий нутаг болох говь орших бөгөөд энд олон зүйлийн ховор болон нэн ховор амьтан тархан амьдардаг юм.

Говийн Их Дархан Газрын Б хэсэг нь тахийг сэргээн нутагшуулахаар сонгосон нутаг бөгөөд 1975 онд улсын тусгай хамгаалалтад авсан 9000 км.кв талбай бүхий цөлөрхөг тал бүхий нутаг юм. Зүүн зах хэсгээрээ ерөнхийдөө тэгш талархуу, баруун хэсгээрээ намхан гувээ толгод зонхилен, өмнөд хэсгээрээ Тахийн шар нуруу, Хөх өндөр, Хавтаг, Байтагийн уулс бүхий нуруугаар хязгаарлагддаг. Тэдгээр уул нуруудын оройгоор хятадын хил залгана, хойд талаар нь Монгол Алтайн өндөр нуруу байршина. Далайн түвшнээс ойролцоогоор 1000-2840м өндөр өргөгдсөн. Цаг уурын хувьд эх газрын уур амьсгал зонхиленсон, урт хугацаанд үргэлжилдэг нилээн хүйтэн өвөлтэй. Зун богинохон аагим халуун болдог. Жилийн дундаж агаарын температур нь 1 хэм орчим, дундаж хур тунадас нь 96 мм. Жилд 97 орчим хоног цасан бүрхүүлтэй байдаг. Ийнхүү.govийн уур амьсгал нь хур тунадаснаас ихээхэн хамааралтай ба хур тунадасны хэмжээ нь жил бүр харилцан адилгүй байдаг. Хамгаалалттай нутагт задгай ус нэлээд хэд байдаг боловч харилцан адилгүй байршилтай. Төв болон баруун хэсгээрээ бараг усгүй хуурай.

Монгол орныг ихэвчлэн "хашаагүй уудам нутаг" хэмээн нэрлэдэг бөгөөд олон зүйл зэрлэг амьтдын эх нутаг гэж үздэг. Социализмын уналтын дараах хүнд үед Монгол Улсын иргэд мал аж ахуйг голлон эрхэлж байсан нь эдийн засгийн амжиргааны эх үүсвэр байсан. Зах зээлийн эдийн засгийн шилжилт, уул уурхай, зам барилгын салбарын үсрэнгүй хөгжлөөс хамааран монгол орны байгаль орчин, ялангуяа.govийн ан амьтдын амьдрах орчинд сөргөөр нөлөөлөх хандлага бий болж эхэлсэн.

## CENTRAL ASIAN TRANSBOUNDARY PEACE PARK

For this re-introduction programme to be successful in the long run, it has to be embedded in a broader context of ecosystem conservation. Horses as well as the far-ranging Asiatic (Mongolian) wild ass (*Equus hemionus*) were fitted with satellite-tracking collars in order to determine their position, home range and habitat preferences. At the onset, data collection was



restricted to the eastern part of the SPA, but today the spatial scale encompasses the entire Gobi region in Mongolia and northern Xingjian in China.

In order to strengthen cross-country co-operation in nature conservation, Przewalski's horses were transported from China to Mongolia in 2012. The border strip between China and Mongolia in the Dzungarian Gobi is sparsely populated and could potentially connect the two Great Gobi "A" & "B" SPAs (together 53,000 km<sup>2</sup>) in Mongolia with the Kaamaili reserve (18,300 km<sup>2</sup>) in China, where there are presently also initiatives to re-introduce Przewalski's horses. If managed in common, the area could potentially constitute a **central Asian Transboundary Peace Park** and thus be one of the largest continuous protected areas of the world.

## ТӨВ АЗИЙН ХИЛ ДАМНАСАН ХАМГААЛАЛТАЙ НУТАГ БИЙ БОЛГОХ

Тухайн нутгийн экосистемийг өргөн хүрээнд хамруулан хамгаалах явдал тахийг сэргээн нутагшуулах төслийг амжилттай хэрэгжүүлэхийн гол үндэс юм. Үүний тулд юуны өмнө тахь болон хуланд зайнаас танадан судлах төхөөрөмж зүүж, тэдний байршил, амьдрах орчин, шилжилт хөдөлгөөнийг судалж байна. Энэхүү судалгааны материал цуглуулах ажил эхэн үедээ зөвхөн Зүүнгарын говийн зүүн хэсгээр хязгаарлагдаж байсан бол одоо Монголын өмнөд говийг бүхэлд нь хамрахын зэрэгцээ Хятадын Шиньжан муржийн зарим нутагт ч хийгдэж байна.

Олон улсын хамтын ажиллагаа, хил дамнасан байгаль хамгаалах үйл ажиллагааг эхлүүлэх, идэвхжүүлэх үүднээс анх удаа 2012 онд Хятадын Шиньжан муржас дөрвөн тахь тээвэрлэн Говийн Их Дархан Газарт авчирсан юм. Хятад, Монгол улсын хил дагуу Зүүнгарын говийн бүс нутаг нь хоёр талдаа хүн ам сийрэг нутагладаг бөгөөд Монголын Говийн Их Дархан Цаазат Газрын А, Б хэсгийн нутаг нийт 53000 км.кв талбай, Хятадын Каламайли нөөц газрын 18000 км.кв талбай бүхий нутгийг нэгтгэн хууль дүрмийн дагуу хил дамнасан хамгаалалттай нутаг бий болгон тэнд тахийг сэргээн нутагшуулах ажлыг өргөжүүлэн хийж болох боломжтой юм. Хэрэв дээрх байдлаар зохицуулж болдог бол энэ бүс нутагт **Төв Азийн хил дамнасан олон улсын** ач холбогдол бүхий дэлхийд хамгийн том дархалсан хамгаалалттай нутгийг байгуулж болох юм.



## THE INTERNATIONAL TAKHI GROUP

With Mongolian independence in 1990, the "Takhin Tal" project in the Dzungarian Gobi was initiated by the German businessman Christian Oswald with the support of a few German and Swiss donors. By the late 1990s, project leadership and management was overhauled, with research and scientific data firmly integrated into the decision making process.

In 1999, the ITG was established as a nongovernmental organisation in Switzerland and Mongolia to continue and extend this project in accordance with the IUCN re-introduction guidelines. The basis for the work of the ITG in Mongolia and also key to success is its close cooperation with the Mongolian government, the national management plans and a long-standing exclusive co-operation contract.

**THE VISION OF ITG IS THE INTEGRAL PROTECTION OF THE GOBI HABITAT AND THE CONSERVATION OF THE GREAT GOBI "B" STRICTLY PROTECTED AREA (SPA) AS A BIOSPHERE RESERVE IN THE SENSE OF THE IUCN.**

### THE PROJECT:

- is sensibly embedded into the overall development of the region
- helps to protect the Gobi habitat, especially through implementation of the management plan
- helps to re-introduce the animals into the wild and ensure their survival
- guarantees the scientific supervision of the project
- guarantees monitoring and care of the Takhis in the Gobi
- promotes media activity and information about the project worldwide
- maintains collaboration with other organisations which are involved in the re-introduction of Przewalski's horses.
- provides support for local people in socio-economic issues
- improves knowledge about the Przewalski's horse within Mongolia

## ОЛОН УЛСЫН ТАХЬ ГРУПП

1990 оны монгол орны эдийн засгийн шилжилтийн үетэй зэрэгцэн германы худалдаачин Христиан Освальдын санаачлагаар герман, швейцарийн цөөн хүмүүсийн дэмжлэгээр Зүүнгарын говьд "Тахийн тал" төслийг эхлүүлсэн. 1990 оны сүүлээр төслийн удирдлагын баг судалгаа, шинжилгээний мэдээ баримтыг няглан нэгтгэж, тахь нутагшуулах шийдвэрийг гаргуулжээ.

1999 онд Олон Улсын Тахь Групп Швейцарь болон Монгол Улсад төрийн бус олон нийтийн байгууллагын статустайгаар байгуулгадж, тахь сэргээн нутагшуулах төслийг IUCN-ын журам, дүрмийн дагуу үргэлжлүүлэн хэрэгжүүлж ирсэн. Олон Улсын Тахь Группын үйл ажиллагааны үндэс нь Монгол Улсын Засгийн газартай байгаль хамгаалах урт хугацааны гэрээ байгуулж, амжилттай хамтран ажиллаж байгаа явдал юм.

**ОУТГЫН ЗОРИЛГО НЬ ГОВИЙН ЭКОСИСТЕМ, АМЬТДЫН АМЬДРАХ ОРЧНЫГ БУХЭЛД НЬ ХАМГААЛАХ, ГИДЦЫН Б ХЭСГИЙГ ОЛОН УЛСЫН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ХОЛБООНЫ ЖУРМЫН ДАГУУ ШИМ МАНДЛЫН НӨӨЦ ГАЗРЫН ТҮВШИНД ХАМААЛАХ ЯВДАЛ ЮМ.**

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Бус нутгийн хөгжлийг хамруулсан байх
- Хамгаалалттай нутгийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх замаар.govийн амьтдын амьдрах орчныг хамгаалах
- Амьтдыг сэргээн нутагшуулахад туслах, байгальд зэрлэг амьтад, тахийн биеэ даан амьдрах чадварыг бий болгох
- Төслийн эрдэм шинжилгээний ажлыг удирдлагаар хангах
- Тахийн мониторинг судалгаа болон арчилгаа маллагааны ажлыг хариуцах
- Төслийг олон улсад сурталчлах, мэдээллэх
- Тахийг сэргээн нутагшуулах ажлыг бусад байгууллагуудтай холбож, хамтран ажиллах
- Орон нутгийн иргэдийн нийгэм, эдийн засгийг дэмжих дэд төслүүдийг хэрэгжүүлэх
- Монгол дахь тахийн талаарх мэдээ, мэдлэгийг сайжруулах

## **ITG'S ROLE IS BASED ON A MANDATE OF THE MONGOLIAN NATION**

Mongolia has a contractual agreement with the ITG concerning the cooperation in the Gobi B National Park. The current contract with the Ministry of Nature Environment and Green Development covers the years 2011 - 2020.

Thus, the ITG maintains close cooperation with the director and the administration of the National Park, but also with the farmers, ranchers, cooperatives and administrations in the region. Furthermore, collaboration extends to the central government, the president and his staff and the Ministry of Nature Environment and Green Development of Mongolia.

ITG assumes leadership and coordination concerning the cooperation with all partners in order to ensure the implementation of the long-term goals. It also guarantees a professional and efficient use of project funds.

The Mongolian government has defined its activities in the "Management Plan of Great Gobi "B" strictly protected Area and Alagkhairkhan Nature Reserve (2011-2015)" and has announced financial support. The ITG played a significant role in the formulation of the Management Plan.

## **ОУТГ НЬ МОНГОЛЫН АРД ТҮМЭНТЭЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД АЖИЛЛАДАГ**

Монгол Улсын Засгийн газар ОУТГ-тай хамтын үзээ байгуулан Говийн Их Дархан Газрын Б хэсэгт үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг. Одоогийн Байгаль орчин ногоон хөгжлийн яамтай байгуулсан хүчин төгөлдөр гэрээ нь 2011-2020 оныг хүртэлх хугацаанд үргэлжлэх бөгөөд 2 дахь удаагаа сунгагдан амжилттай хэрэгжиж байгаа юм. Тиймээс ОУТГ нь тус яамны улсын тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар, орон нутгийн удирдлага, иргэд малчид, нөхөрлөлүүдийн хамтын ажиллагааг дэмжин ажилладаг бөгөөд цаашид Засгийн газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Байгаль орчин ногоон хөгжлийн яамтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэхийг эрмэлзэн ажиллаж байна.

ОУТГ нь төслийн хэтийн зорилго, төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд өөрийн хамтрагч талуудын хамтын ажиллагааг идэвхжүүлэн зохицуулах ажлыг гүйцэтгэж байна. Ингэснээр төслийн үндсэн санхүүжилтийг бий болгох ажлыг хариуцаж байна. Монголын Засгийн газраас ГИДЦГ-ын Б хэсэг, Алаг хайрханы нөөц газрын 2011-2015 оны менежментийн төлөвлөгөөг баталж өгсөн бөгөөд энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг ч тодорхойлж гаргасан. Энэ менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ОУТГ нь гол үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.





## RESEARCH IS THE BASIS FOR SUCCESS

The IUCN requires extensive accompanying research and monitoring for all re-introductions. A permanent field and research station was established in Takhin Tal. The station is located on the north-eastern corner of the Great Gobi "B" SPA. Over the years it has been upgraded, and today it provides the necessary infrastructure (solar power, laboratory, office, vehicles and petrol) and communication abilities (VHF communication, satellite-based e-mail and telephone).

In 2005 facilities at the Takhin Tal camp were further improved with the construction of the SPA headquarters funded by the Austrian Ministry of the Environment and ITG. Facilities now allow year-round living and research.

Under the leadership of Prof. Dr. Chris Walzer and Dr. Petra Kaczensky from the Research Institute of Wildlife Ecology of the University of Veterinary Medicine Vienna in Austria, and in cooperation with the University of Ulan Baatar and further international institutions, researchers carry out scientific investigations. The immediate presence of scientists on location is the basis for a successful long-term re-introduction of the wild horse. Transfer of knowledge and technology will enable Mongolian scientists to manage the project on a long-term basis.

The Takhin Tal camp provides training opportunities for young Mongolian and international scientists, has created local employment options and is run by well-trained and motivated local staff. In 2004 it hosted the second international workshop on the re-introduction of the Przewalski's horse.

## СУДАЛГАА БОЛ АМЖИЛТЫН ҮНДЭС

Олон улсын байгаль хамгаалах холбоо нь амьтдыг сэргээн нутагшуулахад маш олон дагалдах судалгааг хийсэн байх ёстой гэж шаарддаг.

Тахийн талд байнгын ажиллагаатай туршилт эрдэм шинжилгээний төв байгуулагдсан бөгөөд улсын тусгай хамгаалалттай нутгийн зүүн хойд хэсэгт байрладаг. 2005 онд Тахийн тал дахь энэ төв нь Австрийн Байгаль орчны яам, Олон улсын тахь группын санхүүжилтээр хамгаалалтын захиргааны шинэ байр барьж, ашиглалтанд оруулсан бөгөөд дэд бүтцийн хувьд нарны энергийн үүсгэвэр бүхий цахилгаан эрчим хүчтэй, лаборатор, оффис, автомашин, шатахуун түгээх станц, холбооны төхөөрөмжүүд VHF холбооны станцууд, сансрын холбоо, интернэт/-ээр бүрэн хангагдсан нь жилийн турш ажиллаж амьдрах боломжтой тохилог төв болсон.

Австрийн малэмнэлгийн их сургуулийн зэрлэг амьтны экологийн хүрээлэнгийн профессор Хрис Вальцерь, доктор Петра Каченский нарын удирдлага дор Улаанбаатар хотын МУИС-ын Биологи Биотехнологийн сургууль болон Олон улсын эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагаагаар тэнд эрдэм шинжилгээ судалгааг амжилттай хийж байна.

Тухайн орон нутагт байгаа эрдэм шинжилгээний ажилтнуудын идэвхтэй ажиллагаа нь тахийг удаан хугацаанд амжилттай сэргээн нутагшуулах ажлын үндэс суурь болж өгнө.

Монголын судлаач эрдэм шинжилгээний ажилтнуудыг давтан сургах, мэдлэг чадварыг сайжруулан техник хэрэгслээр хангах нь төслийг ирээдүйд амжилттай хэрэгжүүлэх боломжийг бий болгох юм.

Тахийн судалгааны төвд Монголын залуу судлаачид, олон улсын эрдэмтдийн хамтарсан сургалт зохион байгуулдаг нь чадварлаг орон нутгийн мэргэжилтэн бэлтгэх, ажлын байраар хангах үндэс болдог. Тахийн талд тахь сэргээн нутагшуулах Олон улсын эрдэм шинжилгээний хоёрдугаар хурлыг 2004 онд амжилттай зохион байгуулж байсан.



